

Тэвш (Тэгш) -ийн уулаас илрүүлсэн руни бичгийн хоёр шинэ дурсгал

Цэндийн Баттулга^{1,*}

Товч агуулга: Бид 2023 оны 10-р сард Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Тэвш (Тэгшийн улаан) ууланд хийсэн хээрийн судалгааны ажлын хүрээнд руни бичгийн хоёр дурсгал шинээр илрүүлсэн билээ. Тус өгүүлэлд их Дуутын болон Адуун хүрээний Хүрмэн хаданд буй шинэ бичээсийг тайлж уншсан судалгааг толилуулж байна. Их Дуутын бичээс гурван мөр бөгөөд руни бичгийн зураасан бичгийн төрөлд хамаарах бол, Адуун хүрээний Хүрмэн хадны бичээс хоёр мөр, цохимол бичээс юм.

Түлхүүр үг: Тэвшийн уул, Тэгшийн уул, Их Дуут, Хүрмэн, руни бичиг, тамга

Удиртгал

Монголын төдийгүй Төв Азийн хадны зургийн судалгаанд чухал ач холбогдолтой түүхэн дурсгалт газрын нэг бол Өвөрхангай аймгийн Богд сум (хуучин Ховд сум)-ын нутагт орших Тэвш уул юм. Тэвш уулын хадны зургийг А.П.Окладников 1949, 1962, 1976 онуудад судалж улмаар 1980 онд “Петроглифы Центральной Азии. Кобд-Сомон (Гора Тэбиш)” хэмээх нэг сэдэвт бүтээл хэвлүүлсэн байдаг.

Тэрээр хадны зургийн сэдвийг амьтны, хүний, геометрийн гэх гурван төрөлд хувааж, харин зурсан аргыг нь хонхойлон сийлсэн, хурц үзүүртэй багажаар зурсан гэж ангилсан байна. Он цагийн хувьд дөрөв ангилж, ангилал тус бүрд холбогдох зургийг хавсралт, хүснэгтээр харуулжээ (Окладников 1980: 40–59). Үүнд, Тэвшийн хадны зургийн хамгийн түгээмэл байх бодит байдлаар дүрсэлсэн зургуудыг НТӨ 2000 жилээс НТӨ 1500-1300 жилд, загварчилсан дүрслэл бүхий зургийг НТӨ 2000 жилийн дунд үе болон НТӨ 1000 жилд хамаарна гэжээ. Геометрийн дүрслэл бүхий зургуудыг IX-X зуунд, хурц үзүүртэй багажаар зурсан шугаман зургуудыг хожуу дундад зуун буюу XIII-XIX зууны үед холбогдоно гэж үзсэн байна. Академич Д.Цэвээндорж гуай бүтээлдээ уг номын бүлэг тус бүрийг задлан үзэж өөрийн дүгнэлт саналыг дэвшүүлсэн байдаг (1999).

А.П.Окладниковын удирдсан хээрийн шинжилгээний анги 1949 онд Тэвшийн уулнаас руни бичгийн нэгэн дурсгал илрүүлснийг Б.Ринчен гуай 1968 онд гэрэл зургийг нь хэвлүүлсэн байна (1968: 43).

Тэвшийн бичээсийн анхны байрлалыг Н. Сэр-Оджав гуай “Өвөрхангай аймгийн Богд (хуучнаар

Ховд) сумын төвөөс 20 орчим км-ын зайд орших Тэвш гэдэг баруун зүүн тийш хөндөлдсөн хавтгай нурууны өвөрт байсан” (1977: 141) гэж тэмдэглээд Улаанбаатар хотод авчирсан бөгөөд өдгөө ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөгт хадгалагдаж байгаа билээ.

“Тэвшийн бичээс” гэдэг нь 54×42 см хэмжээтэй, говийн хүрэн бор хүрмэн чулуун дээр хоёр мөр, бичээст шууд холбогдох нэг тамга бүхий дурсгал юм.

Бичээсийн эхний мөрийг 1974 онд В.М. Наделев тайлан уншиж судалгааны эргэлтэд оруулжээ (1974: 136–150). Мөн С. Харжаубай (1979: 33), Л.Болд нарын эрдэмтдийн судалгаа бий (1990: 110–112; 2006: 237–241).

Бид 2005 онд хэвлүүлсэн бүтээлдээ бичээсийг танилцуулж (Баттулга 2005: 178–181), дараа нь дахин судалсан үр дүнг хэвлүүлсэн билээ.

Тэвшийн хэмээн алдаршсан “тэвэрт багтам” чулуун дээр

[f]x|>>δfΛf>A .1

МfMf>AЧ>ΛЧfDfΛfЧ>δfΛf>A.2

1. tuγcī boltim äsīd[in] 2. tuγcī burγucī yaγiz čur tuγγaγi

1. Тугч болов би. Сонсогтун. 2. Тугч бүрээч Ягыз чурын тамга (Баттулга 2022: 190–192) гэсэн бичээс бий.

Руни бичгийн дурсгалын зураасан бичгийн төрөлд хамаарах энэ бичээсийн үсэг тэмдэгтийн тиг, шууд холбогдох тамгад тулгуурлан он цагийн хувьд Уйгурын үед холбогдоно хэмээн үзсэн юм.

Их Дуутаас шинээр илрүүлсэн бичээсийн ойр орчимд Тэвшийн гэж нэрлэгдсэн “бичигт чулуу” байсан болов уу. Хадны бүтэц, өнгөнөөс гадна бичгийн тигийн хувьд энэ хоёр бичээс тун дөхүүт тэмдэглэе.

Тэгш, Тэвш хэмээхийн нэрийн тухайд. 1979 онд хэвлэгдсэн Б.Ринчен академич эрхлэн хэвлүүлсэн

¹ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Ази судлалын тэнхим

* Холбоо барих зохиогч: tulga@num.edu.mn

<https://orcid.org/0000-0002-3551-0399>

“Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас”-г (1979) “Тэгшийн улааны бичээс” гэж тэмдэглэсэн нь тухайн үед уг газрын нэрийг байцаан судалж, нутгийн уугуул ардын аман мэдээтэй харьцуулж бичсэн байх (Баттулга 2022: 190). “Тэгшийн улаан” гэж зүгээр ч нэг тэмдэглэж нэрлээгүй болов уу. Уулын харагдах дүр, төрх байдлаар нэрлэсэн “Тэгш” нэр он цаг улирахын хэрээр мартагдсан бололтой. Тэгш уулын нөмөр нөөлөгтэй хотгор хонхор газрыг нутгийнхан газрынх нь хэв шинжээр Тэвш гэх бөгөөд тийм газар байх өвөлжөө хаваржааг Тэвшийн өвөлжөө, хаваржаа гэнэ. Адуу мал сураглах, айл гэр асуухад Тэгш уулын нэрээр бус, харин энгэр суга, бэл хормойн өвөлжөө, хаваржаагаар баримжаалж хэлдэг. Тиймээс ч өргөн хэрэглээтэй Тэвш нэр аажимдаа дөхүү ижил дуудлага бүхий Тэгш нэрийн байрыг эзэлснээр нэр солигдож хэвшсэн бололтой. Тэгшийн уул галт уулын дэлбэрэлтээс үүссэн орой тэгш, уртааш сунаж тогтсон, алсаас үнэхээр тэгш сайхан харагдах уул юм. (Зураг 1)

Тэгш уул уу, Тэвш уул уу гэдгийг нэлээд хуучны газрын зурагт хэрхэн тэмдэглэсэнээр тодорхойлж болох боловч энэ удаад нарийн байцаан үзэж судлах завдал болоогүйг тэмдэглэе.

Тэвшийн судлагдаагүй бичээс. Л.Болд гуай 1986 онд хэвлүүлсэн “БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал” (1986) хэмээх өгүүлэлдээ “Тэвшийн түрэг бичээс II” гэж бүртгэсэн байдаг. Ц.Баттулга 2005 онд хэвлүүлсэн номынхоо “нэр мэдэгдэж буй ч судлагдаагүй дурсгал” гэсэн хэсэгт “Тэвшийн бичээс II. Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг, Тэвш уулнаас олсон бололтой. Одоогоор уул бичээсийн талаар өгүүлэх тодорхой баримт бидэнд үгүй байна” (Баттулга 2005: 108) гэж тэмдэглэжээ.

Хурц үзүүртэй багаж зэвсгээр зурж бичсэн бичээсийг дарж морь зурсан байх бөгөөд морины зураасан зургийг дарсан олон сараачмал зураас буйг зургийн гар хуулбараас тодорхой харагдана (Окладников 1980: 52).

Тэвшийн тус бичээсийн тухайт бидний хамтын судалгааны өгүүлэл удахгүй хэвлэгдэх болно.

А.П.Окладниковын “Петроглифы Центральной Азии. Кобд-Сомон (Гора Тэбиш)” номд хэвлэгдсэн бичээсийг нүдээр үзэж судлах зорилгоор Тэвш (Тэгшийн улаан) ууланд хээрийн хайгуул судалгаа хийсэн ч уг бичээс олдоогүй юм.

Бид 2023 оны 10-р сард хийсэн судалгааны үр дүнд Тэвш уулаас руни бичгийн хоёр дурсгал шинээр илрүүлэв. Их Дуутын бичээс нь бага Тэвш уулын бэлийн их Дуутын өвөлжөөнөөс нэлээд зайтай, баруун хойд энгэрт байна. Бидний өмнө дурдсан “Тэвшийн бичээс” гэж алдаршсан бичээс ч мөн энэ газар орчимд нь байсан бололтой.

Их Дуутын өвөлжөөнөөс гурав дөрөв орчим км-

ийн зайтай Адууны хүрээний эхний Хүрмэн хаданд мөн хоёр мөр бичээс буйг илрүүлсэн билээ.

Археологич Б.Буян-Орших Тэвшийн хоёрдугаар бичээсийг дахин хайж олоод судлах санал гаргаж байсны ачаар уг бичээсийг судлахаар зорьж хээрийн судалгаа хийсний үр дүнд эдгээр руни бичгийн шинэ дурсгал илрүүлсэн болохыг онцлон тэмдэглэе.

Үүний учир, энэ далимд Б.Буян-Оршихдоо гүнээ талархал илэрхийлж эрдэм судлалын их ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье.

Бид Их Дуут, Адуун хүрээний Хүрмэн хадны бичээсийн судалгааг тус тусад нь танилцуулъя.

Их Дуутын бичээс

Өвөрхангай аймгийн Богд сумын Баянтөхөм багийн нутаг, Бага Тэвш (уг нэр нь Тэгш)-ийн уулын зүүн өмнө бэлд, хуучин Богд сумын төвийн харалдаа ард их, бага Дуут буюу заримдаа бас баян Тэвш ч гэх саахалтын зайтай хоёр өвөлжөө бий.

Саахалт хоёр өвөлжөөний баруун талыг Их Дуутын өвөлжөө гэх бөгөөд өвөлжөөний энгэр бэл, хормойн хад чулуунд хүрлийн үед холбогдох хадны зураг ихтэй.

Өвөлжөөнөөс нэлээд зайдуу, баруун хойно хүрмэн чулуунд гурван мөрөөр бичсэн руни бичээс шинээр илрүүлэв (Зураг 2). Бичээсийг хүрэн бор өнгөтэй, ургаа хүрмэн чулууны өмнө зүг харсан толигорт хурц үзүүртэй багаж зэвсгээр тиг хэлбэр сайтай тун чадамгай, маш нарийн зурж бичжээ (Зураг 3).

Бичээсийн нэгдүгээр мөрийг чулууны оройгоос 16 см доор, чулууны зүүн ирмэгээс 2 см зайтай бичжээ. Мөрийн урт 10.5 см, 8 үсэгтэй, үсгийн өндөр 8-12 см. Хоёрдугаар мөрийг хадны зүүн ирмэгээс 3 см зайтай бичсэн байна.

Мөрийн урт 15.5 см, 13 үсэгтэй, үсгийн өндөр 6-10 см. Гуравдугаар мөрийг хадны зүүн ирмэгээс 12 см зайтай бичсэн байна. Мөрийн урт 17.5 см, 14 үсэгтэй, үсгийн өндөр 5-10 см. Бичээст шууд болон дам холбогдох тамгагүй.

Гэхдээ өвөлжөөний баруун хойд энгэрийн хаданд нэг хоёроор, бас нэжгээдийг зэрэгцүүлж сийлсэн, Уйгурын үед холбогдох тамга цөөн боловч буйг тэмдэглэе.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

ᠠᠨᠢᠯᠠᠭᠤᠨ.1
ᠠᠨᠢᠯᠠᠭᠤᠨᠠᠨᠢᠯᠠᠭᠤ.2
ᠠᠨᠢᠯᠠᠭᠤᠨᠠᠨᠢᠯᠠᠭᠤᠨᠠᠨᠢᠯᠠᠭᠤ.3

Үсгийн галиг:

1. b n b ᠡ B ᠴ i
2. Q R a B W D N Q a b ü k a
3. T W T m s Y G i Y W u Q r m s

2. Кутлуг чур

Янгир авлаж буйг дүрсэлсэн хүрлийн үеийн зургийн дээд талд ᠴᠢᠯᠢᠭ ᠴᠢᠷ qutluy čur гэж бичихэд хадны ирмэгт тулсан учир ᠪᠠᠳᠢᠵᠢᠮᠢᠰ bādizmis гэх үгийг түүний дээр бичсэн бололтой. Хаданд байх байрлалаараа нэг, хоёрдугаар мөр мэт харагдавч ᠪᠠᠳᠢᠵᠢᠮᠢᠰ qutluy čur bādizmiš - Кутлуг чур урлав гэсэн нэг өгүүлбэр юм.

Зураасан бичээсийг бичихтэй адил хурц үзүүртэй багажаар зурсан бус, сонгодог бичгийн адил гүнзгий ухаж сийлээгүй, хээ угалз байдлаар урлаж бичсэнээ онцолж, товойлгон илэрхийлэхийн тулд ᠪᠠᠳᠢᠵᠢᠮᠢᠰ bādizmiš - урлав, чимэглэв, урлажээ, чимэглэжээ гэх үгийг сонгон авсан бололтой.

Монголын руни бичгийн бага дурсгалд анх удаа урлах, хээлэх, чимэглэх гэх үгээр “урлан бичив, хээлэн бичив” гэсэн утга санааг илэрхийлж “бичив” гэдэг үгийг хэрэглээгүй байна.

ᠪᠠᠳᠢᠵ bādiz нь хээ, угалз, чимэг гэсэн утгатай. Түрэг, Уйгурын үеийн тахилын онгоны сүмийн хээ чимэглэл, гэрэлт хөшөө, мэлхий чулуун суурь, хүн чулуу, тахилын хавтан, арслан, хонь зэрэг чулуун урлалыг руни бичгийн дурсгалд bādiz гэдэг, харин түүнийг урлагч урчуудыг bādizči гэнэ.

Доктор Н.Гэрэлмаа “бичиг сийлэх, хөшөө босгох”-ыг үйлдсэн байдлаас шалтгаалан “biti- бич-; bediz- сийл-; ur- цохи-; toqi- тогши-; yarat- босго-; qir – цоол-, цоолборло-” гэх мэт үг хэллэгийг сонгон хэрэглэсэн байдгийг дурдаад ᠪᠠᠳᠢᠵ bādiz гэдэг үгийн утгыг монгол хэлний баримтаас сурвалжлан судалжээ (2008).

Тэрээр судалгаандаа “Хэлбэр, утга болоод эх бичээст илтгэх шилжсэн утгад түшиглэн монгол хэлний *bider* ‘бидэр’, *bidertükü* ‘бидэртэх’, *biderlekü* ‘бидэрлэх’ гэх мэт үгстэй холбон үзэх саналтай байна. Түрэг төрөл хэлний *z* гийгүүлэгч монгол төрөл хэлний *г* гийгүүлэгчийн тохирох зүй тогтолын дагуу *bediz-bider* гэдэг нь *boz* (түрэг хэл) ба *boru* (монгол хэл), *öz* (түрэг хэл) ба *öber* (монгол хэл) гэх мэт жишээ үгийн нэгэн адил гарал язгуур нэг, нийтлэг тохиолдож байгаа үг мөн болно. Монгол хэлэнд энэ язгуураас дараах мэт төрөл үгийн үүр үүссэн байна. Үүнд: *бидэр* - амьтны биеийн арьс үсэнд тогтсон өөр өнгийн бяцхан толбо буюу зурвас, жижигхэн зурвас толбо мэт болгон гаргасан хээ; *бидэрлэх* - юман дээр бидэр гаргах, бидэртэж харагдах, голын ус бидэртэх; *бэжирмэг* - жижиг бэжрүү; *бэжирмэгтэх* - бэжирмэг тогтох; *бэжрүү* - юманд бий болсон жижиг бөм ширхэг. Мөн “Монгол үгсийн язгуурын толь”-д *biči* (жижиг болох)-язгуураас үүсэлтэй хэмээгээд *bičil*, *bičiqan*, *bijir*, *bijirei*, *bijermeg*, *birjüki* гэх мэт үгсийг холбон үзсэн байна. Усны бидэрлэн урсах, уулсын бидэртэн харагдах нь монгол хэлний жижиг, жижгэрэх утга бус түрэг хэлний угалзрах, хээтэх утгад илүү ойртож байгаа мэт боловч тоймгүй олон жижиг зүйл болоос

харахад хээ угалз мэт харагддаг байдлыг харгалзан үзвэл “жижиг” хэмээх утгаас “хээ угалз” гэсэн утга үүссэн байна” (Гэрэлмаа 2008; 2022) гэжээ.

Руни бичгийн дурсгалын үгийн утгыг бүрэн гүйцэт тайлбарлахын тулд эрт, дундад үеийн бичгийн сурвалжийн мэдээ баримтаас гадна төрөл хэлний болон нутгийн аялгууны үгс ямар үнэ цэнтэй чухал эх хэрэглэгдэхүүн болохыг энэхүү судалгаанаас харж болно.

Монгол нутгаас ᠴᠢᠯᠢᠭ ᠴᠢᠷ qutluy čur цолтонд холбогдох цөөнгүй бичээс илэрчээ.

Үүнд; Монголын руни бичгийн сонгодог дурсгалаас Түрэгийн хожуу хаант улсын үеийн Күли чур, Хиргисийн овооны Йэгин чурын бичээс, Уйгурын хаант улсын эхэн үеийн Могойн шинэ усны Моюн/Баян чурын гэрэлт хөшөөний бичээс тус тус чур цолтонд зориулагдсан ажээ.

Судлаач Т. Загарпэрэнлэй, Д. Содномжамц нар Өвөрхангай аймгийн Төгрөг сумын Өлзийт хайрхан уулын зүүн хойд талд байх Даахь хэмээх газраас шинээр илрүүлсэн бичээсийг уншиж тайлсан судалгаандаа чур цолд холбогдох дурсгалуудыг бүртгэжээ (2023). Бидний бүртгэснээр руни бага бичгийн арван зургаан дурсгалд 18 удаа чур цол тэмдэглэгдсэнээс Тайхир чулууны хар бэхэн бичсэн гурван удаа тохиолдоно. Хүрмэн хадны шинээр илрүүлсэн эл бичээс Монгол нутгаас илэрсэн чур цол тэмдэглэгдсэн арван ес дэх дурсгал болж байна.

Түрэг, Уйгур нар “тэнгэрээс заяат” өндөр дээд язгууртайг qutluy гэдэг үгээр илэрхийлж байсан тул тухайн цаг үеийн хамгийн өргөн хэрэглээтэй эрхэм дээд үг байжээ.

ᠴᠢᠯᠢᠭ ᠴᠢᠷ qut -хувь, хишиг, заяа, хувь хишиг, хувь заяа үгэнд +luy дагавар залгаж уг юм бүхий, уг юм агуулагдсан болохыг заасан ᠴᠢᠯᠢᠭ ᠴᠢᠷ qutluy - хувь хишигтэй, хувь заяатай буюу хувь хишиг бүхий, хувь заяа бүхий гэсэн утгатай үг бүтжээ. Бурхны шашны холбогдох ном зохиолын уйгур орчуулгаар дамжиж монгол хэлэнд нэвтэрч өлзий хутаг, хутаг өлзий гэх зэргээр хоршиж бас дангаараа ч хэрэглэгдэх болжээ.

Уйгур улс маанийн шашныг төрийн шашинд өргөмжилсөн нь үнэн боловч өмнө дэлгэрсэн бурхан шашны ном сургаалын үндэс язгуур байснаас гадаад хэлбэр нь маанийн шашны шинжтэй, мөн чанартаа бурхны шашны үндэс суурьтай байсан бололтой. Уйгурын эртний нийслэл Хар балгас болон ер нь Монгол нутгаас илэрч буй Уйгурын үеийн археологийн олдвор эх хэрэглэгдэхүүн маанийн шашинд бус, харин бурхны шашны холбогдолт эд зүйлс илүүтэй олон байгаа нь үүний нэгэн баталгаа гэж хэлж болох юм.

Түрэгийн түрүү хаант улсын үед бурхны шашин тодорхой хэмжээгээр дэлгэрч байсныг Бугатын гэрэлт хөшөө, Хүйс толгойн гэрэлт хөшөө нотолно.

Хүрмэн хад хэмээх бичээс бүхий энгэрээс Тэвш уулын өмнө, баруун өмнө этгээдээс Арцатын нурууг бэллэж, Ховд гол, Элгэн булаг, цаашлан Их Богдын бэлээр явах гол зам алган дээр тавьсан мэт харагдана. Газрын энэхүү онцлог байршил, байрлалаас харахад толгойн сэргийлэх, харуул манааны алба гүйцэтгэж байсан Кутлуг чур хэмээгч Хүрэмт хаданд бичээс бичсэн бололтой.

Бичээст шууд холбогдох тамга байхгүй боловч Карлук аймгийн тамгыг бичээсээс нэлээд зайтай сийлж үлджээ. Нэг цаг үеийн дурсгал мөн эсэхийг тогтоох боломжгүй ч юутай Карлук аймгийн цэрэг, захирагч энд ирсэн, байсныг тэмдэглэн үлдээжээ.

Хүрмэн хадны бичээсийн ᠠ Т болон бусад үсэг тэмдэгтийн тигээс ажиглахад, он цагийн хувьд Уйгурын үед холбогдох нь тодорхой байна.

Abstract

Newly discovered two runic inscriptions from Tegshiin Uul

Tsend Battulga

In the article, the author published the results of reading and studying two newly discovered runic monuments in October 2023 in Mongolia.

The Ikh Duut Inscription. It was discovered in a location named Ikh Duut in Tevsh (Tegshiin Ulaan) mountain, Bogd soum region of Övörkhangaï province. The initial line of the inscription consists of eight letters, with the letter height ranging from 8 to 12 centimeters. The second line consists of 13 characters, with each letter having a height ranging from 6 to 10 centimeters. The third line consists of 14 characters, with each letter having a height ranging from 5 to 10 centimeters.

Runic Text:

ᠠᠨᠪᠠᠨᠠᠪᠢᠴᠢ.1
 ᠶᠠᠨᠪᠣᠳᠤᠨᠴ᠋ᠠᠪ᠋ᠦ.2
 $\text{ᠲᠠᠮᠤᠮᠢᠰᠢᠶᠠᠶᠢᠶᠠᠷᠢᠮᠢᠰᠢ.3}$

Transcription:

1. bān bān abīcī
2. qara bodunqa bōkā
3. tutmīš yaγī yoq ārmiš

Translation: I am Beng Abichi. I governed the people with rigor. There was no enemy.

According to the content of the inscription, a historical event is described, such as the suppression of rebellions and uprisings among the local people and the absence of any internal opposition.

The Khürmen Khad Inscription. It was discovered in Baga Tevsh Mountain, Bogd soum, Övörkhangaï province. The first line of the inscription has 5 letters, the height of the letters is 5~8 cm, the second line has 8

letters, the height of the letters is 6~8 cm.

ᠲᠡᠪᠢᠰᠢᠨᠤᠯᠤᠯᠤᠰᠤ qutluγ čur bādizmiš – Kutlug Chur, crafted it. It is a unique monument that uses the word ᠪᠠᠳᠢᠵᠢᠮᠢᠰᠢ bādizmiš - crafted, decorated, instead of the word “write” for the first time in a runic monument. It is dated to the Uighur Khaganate Period.

Keywords: Tevsh Uul, Tegshiin Uul, Ikh Duut, Khürmen, runic inscription, tamga /sign, seal/

Ном зүй

Kaşgarlı Mahmut. (1999). Divanü Lugat-İt-Türk (Dizini): Vol. Cilt IV (Besim Atalay, Trans.). Türk Dil Kurumu Yayınları: 524.

Mehmet Ölmez. (2012). Orhon-Uygur Hanlığı Dönemi, Moğolistan’daki Eski Türk Yazıtları (Metin-Çeviri-Sözlük).

Rintchen, B. (1968). Les Dessigns Pictographiques et les Inscriptions sur les Rochers et sur les Steles en Mongolie: Vol. fasc.1. Instituti Linguae et Litterarum Academiae Scientiarum, Reipublicae Populi Mongolici.

Азаяа, Б. (2013). Уйгурын үед холбогдох руни бичгийн сонгодог дурсгалын судалгаа(Эх бичиг, үгийн сангийн судалгаа) [Доктор (Ph.D)-ын зэрэг горилх нэгэн сэдэвт зохиол]. Монгол Улсын Их Сургууль.

Баттулга, Ц. (2005). Монголын руни бичгийн бага дурсгалууд.

Баттулга, Ц. (2022). Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа: Vol. II: Монголын төв, умард бүс нутаг дахь руни бичгийн дурсгал.

Болд, Л. (1986). БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал. Шинжлэх ухааны академийн мэдээ, №3, 65–87.

Болд, Л. (1990). БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс.

Болд, Л. (2006). Орхон бичгийн дурсгал II. Шинжлэх ухааны академи, Хэл зохиолын хүрээлэн.

Буян-Орших, Б., Баттулга, Ц. (n.d.). Тэвшийн судлагдаагүй нэгэн бичээс. Хэвлэлтгэд.

Гэрэлмаа, Н. (2008). Монголын руни бичгийн дурсгалд “дурдатгагч болон бичигч”-ийн тухай тэмдэглэсэн нь. Монгол судлал, МУИС, МХСС, Эрдэм шинжилгээний бичиг, Боть. XXVIII(294), 164–170.

Гэрэлмаа, Н. (2022). Их Асгатын руни бичээст тэмдэглэсэн “ ᠪᠠᠳᠢᠵᠢ bediz” хэмээх үгийн тухай. The 8th International Conference on Asian Studies, Vol.VIII, 179–183.

Загарпэрэнлэй, Т., Содномжамц, Д. (2023). Даахийн бичээс. The 9th International Conference on Asian Studies, Vol. IX.

Наделяев, В.М. (1974). Древнетюркская надпись из Ховд сомона МНР. In Бронзовой и железный век Сибири (136–150).

Наделяев, В.М., Насилов, Д.М., Тенишев Э.Р., Щербак, А.М. (Eds.). (1969). Древнетюркский словарь.

Окладников, А.П. (1980). Петроглифы Центральной Азии.

Ринчен, Б. (Ed.). (1979). Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас (Vols. 1, 2). БНМАУ, Шинжлэх Ухааны Академи.

Сэр-Оджав, Н. (1977). Монголын эртний түүх

(Археологийн найруулал).

Төмөртоого, Д. (2018). Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь (Эрдэм шинжилгээний эх хэрэглэгдэхүүн).

Харжаубай, С. (1979). Эртний гурван бичээс. *Studia Archaeologica*, Tom.VII(Fasc.12).

Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь.

Цэвээндорж, Д. (1999). Монголын эртний урлагийн түүх (I).

Цэвээндорж, Д. (2020). Монголын эртний урлагийн түүх (II).


Received: March 25, 2024; Revised: Apr 2, 2024; Accepted: Apr 30, 2024



Зураг 1. Тэвш (Тэгшийн улаан) уул



Зураг 2. Их Дуутын бичээс



Зураг 3. Их Дуутын бичээсийн гар зураг



Зураг 4. Хүрмэн хадны бичээс



Зураг 5. Хүрмэн хадны бичээсийн гар зураг